



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrt.gov.mn,
Цахим хуудас: www.mrt.gov.mn

2024-08-05 № 08/53

танай _____-ны № _____-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Зам, тээврийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/160 дугаар тушаал гарч, дулааны цахилгаан станцуудын нүүрсний нөөц бүрдүүлэх, сайжруулах шахмал түлшний тээвэрлэлтийг зохион байгуулах болон Монгол Улсад түрээсээр ашиглах хагас болон тавцант вагоныг хилээр нэвтрүүлэхийг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2 жилийн хугацаанд хязгаарлах, одоо ашиглагдаж буй түрээсийн хагас болон тавцант вагоныг дунд засварт орох хүртэл хугацаанд тээвэрт ашиглахыг зөвшөөрсөн.

Иймд дээрх тушаалын хэрэгжилтийг хангах, танай байгууллагын мэдээллийн санд бүртгэлтэй түрээсийн хагас болон тавцант вагон эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд энэхүү тушаалын талаарх мэдээллийг хүргэж ажиллахыг хүсье.

Зам, тээврийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/160 дугаар тушаалыг хавсаргав.

Хавсралт: 1.. хуудастай.

ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ХИРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ _____ Х.ИТГЭЛТ



00000007

Боловсруулсан: Б. Цыр

Хянасан:

Хувь: 2

Огноо: 2024.08.05



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/160

Улаанбаатар хот

Төмөр замын тээврийн үйл ажиллагааны
талаар авах зарим арга хэмжээний тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төмөр замын тээврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 10 дугаар зүйлийн 10.1.1, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/99 дүгээр тушаалын хавсралт "Монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам"-ын 3.9 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах талаар өгсөн үүргийн хүрээнд дулааны цахилгаан станцын нүүрсний болон сайжруулсан шахмал түлшний түүхий эдийн (мидлинг) нөөц бүрдүүлэх, өвлийн бэлтгэл хангах зорилгоор тус тээвэрт өөрийн эзэмшлийн хагас вагоныг түрээсээр ашиглуулахыг "Монголын төмөр зам" ТӨХК (Б.Отгонсүх), "Тавантолгой төмөр зам" ХХК (Н.Будбаяр), дээр дурдсан нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааг саадгүй, шуурхай зохион байгуулахыг "Улаанбаатар төмөр зам" ХНН (Х.Хэрлэн)-д тус тус даалгасугай.

2. "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн суурь бүтцийн техникийн хүчин чадал, багтаамжийг хөдлөх бүрэлдэхүүний хэмжээтэй уялдуулах, вагон эргэлтийн хугацааг багасгах, ачаа тээврийн үйлчилгээг шуурхай зохион байгуулах зорилгоор Монгол Улсад түрээсээр ашиглах хагас болон тавцант вагоныг хилээр нэвтрүүлэхийг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай хязгаарлах, одоо ашиглагдаж буй түрээсийн хагас болон тавцант вагоны дунд засварт орох хүртэл хугацаанд тээвэрт ашиглах арга хэмжээ авахыг Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газар (Х.Итгэлт), "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" УТҮГ /А.Буяннэмэх/, "Улаанбаатар төмөр зам" ХНН (Х.Хэрлэн)-д тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (А.Мөнхбат)-т үүрэг болгосугай.

САЙД



Б.ДЭЛГЭРСАЙХАН

00000047